

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ
ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ**

**3 дугаар хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тойм №3
2018.05.09**

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харъяа Идэр, Онон-Улз, Хануй, Хараа-Ерөө голын сав газрын захиргааны дарга (ахлах түшмэл ТЗ-8)-ын албан тушаалд сонгон шалгаруулалт явуулсан дүн, тухайн ажлын байрны албан тушаалд дүгнэлт гаргуулах, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>1.Баярсайханы Пүрэвдоржийг, Тогтохбаатарын Шугарыг Идэр голын газрын захиргааны даргын албан тушаалын, Батсуурийн Баяртогтохыг Онон-Улз голын сав газрын захиргааны даргын албан тушаалын, Дамдинсүрэнгийн Бямбажаргалыг, Отгоны Бат-Эрдэнийг, Галсанпунцагийн Үйлстөгөлдөрийг Хануй голын сав газрын захиргааны даргын албан тушаалын, Өлзийхүүгийн Ариунбаатарыг Хараа-Ерөө голын сав газрын захиргааны даргын албан тушаалын нөөцийн жагсаалтад бүртгэж тогтоол гаргахаар тогтов.</p> <p>2.Сонгон шалгаруулалтын дүнгээр 1 дүгээр байр эзэлсэн Баярсайханы Пүрэвдоржийг Идэр голын сав газрын захиргааны даргын албан тушаалд, Батсуурийн Баяртогтохыг Онон-Улз голын сав газрын захиргааны даргын албан тушаалд, Дамдинсүрэнгийн Бямбажаргалыг Хануй голын сав газрын захиргааны даргын албан тушаалд, Өлзийхүүгийн Ариунбаатарыг Хараа-Ерөө голын сав газрын захиргааны даргын албан тушаалд тус тус нэр дэвшүүлж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад томилуулахаар санал болгов.</p>
2	<p>Цаг уур, орчны шинжилгээний газрын Хөвсгөл, Баянхонгор, Говь-Алтай аймаг дахь Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарын нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, дүгнэлт гаргаж өгөх тухай 2018-04-24-ний өдрийн 1/315 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгын тухай</p>	<p>1.Цаг уур, орчны шинжилгээний газрын даргаас 2018-04-24-ний өдрийн 1/315 тоот албан бичгээр Хөвсгөл, Баянхонгор, Говь-Алтай аймаг дахь Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарын нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, дүгнэлт гаргаж өгөх тухай ирүүлсэн захиалгын тухай хэлэлцээд Шүүхийн шийдвэрийн дагуу Хөвсгөл аймаг дахь Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Адъяасүрэн, Баянхонгор аймаг дахь Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Оюунчимэг, Говь-Алтай аймаг дахь Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Алтантуяа нарыг өмнөх албан тушаалд эгүүлэн томилж байгаа болон уг албан тушаалд анх томилогдохдоо Цаг уур орчны шинжилгээний</p>

газрын даргын захиалгаар салбар зөвлөлөөс 2013, 2014 онд зохион байгуулсан Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журмын дагуу шалгалт өгч томилогдсон тус 3 аймгийн төвийн даргаар томилон ажиллуулах шаардлага хангасан тул эдгээр ажлын байранд сонгон шалгаруулалт зарлах шаардлагагүй гэж үзэв.

2.Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор “аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний алба” гэж, Байгаль орчин, аялал жуулчлалын Д.Оюунхорол сайдын 2016 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/32 дугаар тушаалаар “аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний газар” гэж, Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 60 дугаар тогтоолоор “аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төв” болгон тус тус өөрчилсөн боловч чиг үүрэг, орон тоо хэвээр байгаа болно.

Иймд Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын “Найм” дугаар зүйлийн 8.4-т “Сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг удирдах албан тушаалд томилохгүй” гэж заасны дагуу сонгон шалгаруулалтад ороогүй удирдах албан тушаалд томилогдсон дарга нарыг эхний хагас жилд багтаан захиалга ирүүлж, журмын дагуу шалгалтанд хамруулах, дүгнэлт гарсаны дараа даргаар томилохыг Төсвийн төвлөрүүлэн захирагч, салбар зөвлөлийн гишүүн С.Энхтүвшинд үүрэг болгов.

3.Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшингийн хэлсэн Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоотой биечлэн уулзсан гэсний дагуу Цаг уур, орчны шинжилгээний газраас Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн албан бичгийн хариуг ирэхээр салбар зөвлөлд танилцуулахаар тогтов.

4.Цаг уур, орчны шинжилгээний газрын Хөвсгөл, Баянхонгор, Говь-Алтай аймаг дахь Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарын нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, дүгнэлт гаргаж өгөх тухай 2018-04-24-ний өдрийн 1/315 тоот албан

		<p>бичгийн хариуг хүргүүлэхийг салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Бадамдуламд үүрэг болгов.</p>
3	<p>Бусад /салбар зөвлөлд хандсан өргөдлийн тухай/</p>	<p>1.Нийслэлийн Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн Нэгдүгээр хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн дарга Хошууч Б.Алтангадасаас 2017-11-22-ны өдрийн 14^{с-3}/5954 дугаар албан бичгээр Улсын Ерөнхий прокурорын орлогч Б.Амгаланбаатар нь иргэн Ч.Бээжинхүүгийн гаргасан гомдлын дагуу 2017 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 1/572 дугаартай “Хэргийг хэрэгсэхгүй болгох тухай прокурорын тогтоолыг хүчингүй болгож, мөрдөн шалгах ажиллагаа явуулах” тухай тогтоол үйлдэн мөрдөн шалгах ажиллагааг сэргээн явуулж байгаа тухай хариу ирүүлсэн тул дээрх 201301051030 дугаартай хэргийг шийдвэрлэгдтэл хугацаагаар уг өргөдлийг шийдвэрлэх боломжгүй хариуг Яамны Хуулийн хэлтсээс Т.Эрдэнэчимэгт хүргүүлсэн.</p> <p>2.2012 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн “Засгийн газрын бүтцийн тухай” Монгол Улсын хуулиар Ерөнхий чиг үүргийн:1/Байгаль орчин, ногоон хөгжлийн яам; 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Засгийн газрын бүтцийн тухай” Монгол Улсын хуулиар Ерөнхий чиг үүргийн:1/Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам;2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн “Засгийн газрын бүтцийн тухай” Монгол Улсын хуулиар Ерөнхий чиг үүргийн:1/Байгаль орчин, аялал жуулчлалын яам болж тус тус батлагдсан. Үүний дагуу “Яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг батлах тухай” Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 29-ны өдрийн 63 дугаар тогтоолоор Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, “Яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 402 дугаар тогтоолоор Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, “Зарим яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2016 оны 9 дүгээр сарын 21-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл</p>

		ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг тус тус шинэчлэн баталсан тухай албан бичиг хүргүүлэх нь зүйтэй гэж үзэв.
--	--	---

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 3 дугаар хуралдаан 2018 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 11 цаг 30 минутаас 301 тоот өрөөнд болов.

Салбар зөвлөлийн хуралдаан №3 (2018.05.09)